

ЗУРГААН АЛХАМ

Дүрслэх урлаг, технологийн хичээлээр сурагчид өөрийгөө үнэлэх хангалттай боломж

Михаил КУДЕЙКО, ОХУ-ын Начальная школа сэтгүүлийн 2013 оны 12 сарын дугаар №95

Беларусийн 3-4-р ангийн дуу хөгжим, биеийн тамир, технологи, дүрслэх урлагийн багш нар “Албан бус үнэлгээт сургалт”-ын талаар хоёр жилийн турш идэвхтэй хэлэлцэж байна. Сурагчид сурах явцдаа албан бус үнэлгээг өөртөө тавьж, сурах үйл ажиллагаагаа хянах чадварт суралцаж байгаа нь багш нарыг уриалан дуудсан, сургалтын үйл явц, зохион байгуулалт, хэрэгжилтэд гарч буй цоо шинэ чиг хандлага мөн гэж үзэх боллоо. Бага боловсролын сургалтын явц дахь албан бус үнэлгээний сургалт нь боловсролын систем дэх “Суралцагч төвтэй” сургалтын шинэлэг төрөл юм.

Өөрийн ашиг, сонирхол, нөөц чадвартаа итгэлтэй хувь хүүхэд бол сурган хүмүүжүүлэгч багш бидний анхаарлын төвд байх ёстой зүйлийн нэг юм.

Албан бус үнэлгээний сургалт нь өөрийн ашиг сонирхол, чадварын түвшинд өөрийгөө үнэлэх, харилцан үнэлэх үндсэн дээр сургалтыг сонирхолтой болгох, хүүхэд өөрийгөө олж харах боломжийг олгодог байна. Өмнөө тавьсан зорилго, зорилтыг хэрэгжүүлснээр хүүхдэд шаардлагатай мэдлэгийг дэмжих таатай орчныг буй болгох, үр ашигтай инновацийг хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ.

Ийм орчныг буй болгоход багш нарын зүгээс хөтөлбөрийн баримт бичигт тусгагдсан дэвшилтэт технологийг өөрийн болгох, ухамсартай шийдвэр гаргах, суралцагчийнхаа хөгжих үйл ажиллагааг хангах, орчин бүрдүүлэх, тэдний дээд зэргийн чадвар чадавхыг ойлгох боломжийг олгодог.

Бага боловсролын сургалтын явцад албан бус үнэлгээт сургалтыг хэрэгжүүлэх багш болоод орчин үеийн боловсролын стандартыг буй болгосноор эцсийн дүнд суралцагч төвтэй сургалтад суурилсан хүүхдийн төлөвшил, хөгжлийн гол гол хандлагыг тодорхойлсноор боловсролын системийн бүтцэд өөрчлөлт орно.

Суралцагчийн хувийн онцлог, үр чадварт бага ангийн сурагчийн мэргэжлийн мэдлэг,

хувь хүний хөгжлийн асуудал ямар үүрэгтэйг шинэ стандартад тусгах эсэхийг тодруулахад багш тусална. Үр дүнтэй арга, үнэлгээний үйл ажиллагаа нь суралцагчдад суралцах хүсэл эрмэлзэл, сурах арга зүйн бэлэн байдлыг буй болгохын зэрэгцээ сургалт амжилттай болох, тэдэнд өөртөө итгэх итгэлийг буй болгоно.

Та бүхний анхааралд зохиогчийн боловсруулсан бага боловсролын дүрслэх урлаг, технологийн хичээлээр суралцагчдыг хөгжүүлэх арга аргачлалаас толилуулж байна.

“БИЧИЛ ТАЙЛАН”-гийн арга

Тайлан бичихдээ дараах зарчмуудыг баримтална. Үүнд:

Хүртээмжтэй байх (Ямар ч хичээл, ямар ч багшийг хамарч болно);

Үр ашигтай байх (Ёс суртахууны наад захын);

Сургалтад сэтгэлээсээ хандахад сурагчдын дотоод сэтгэцийн үйлд хангалттай цаг гаргах;

Өөрийгөө үнэлэх үнэлэмж буй болгох;

Бие дааж өөрийн сурах үйл ажиллагааны үр дүнг үнэлэх боломжийг бий болгох;

Ажиглалт (Сурагчийн ажлыг харааны анализаторын тусламжтайгаар үнэлж болох туршилтын картыг багш ашиглах).

Ойлголт (Суралцагч нэг бүр өөрийгөө албан бус үнэлгээгээр үнэлэх шалгуур боловсруулахад оролцдог байх);

Үр дүн (Хүүхэд бүрийн гүйцэтгэлийг засаж залруулах ажлыг төлөвлөх;

Оновчтой байдал (Сурагчдын бие бялдар, ёс зүйн төлөө гаргаж буй зардлыг багасгах, анги танхим, багш нарын цагийг хэмнэх ... зэрэг байх болно.)

НЭГДҮГЭЭР АЛХАМ

Шалгуур үзүүлэлтийг тодорхойлох

Зорилго:

Сурагчид юундаа илүү амжилт гаргаж байгааг



тодорхойлох, үр дүнгийн үнэлгээнд бодитой ахиц гаргах сурагчдыг өөрийгөө хүндэтгэх болон үнэлгээний нөхцөл бүрдүүлэхэд оршино.

Багш хүүхдийн ажлыг бодитой үнэлэхийн тулд сурагчдад хэрэгцээтэй шалгуур үзүүлэлтүүдийг түүнтэй хамтран боловсруулах шаардлагатай.

Энэ нь тэдний санаа бодлыг ойлгож, ухамсартайгаар хяналт тавьж, тэдний үйл ажиллагаанд шударга, бүрэн эрхтэйгээр оролцох боломжийг нээж байгаа арга хэрэгсэл гэж үзэж болно. Шалгуур үзүүлэлтүүдийг ээлжит хичээлийн өмнө сурагчтай хамтран боловсруулсан байна. Ийм ажлыг бүр 1-р ангиас л эхлэх ёстой. Эхлээд сурагч, багш нар өөрсдийн боловсруулсан үйл ажиллагааны үнэлгээний шалгуур болгон ямар боломж олгож байгаад анхаарал хандуулж ярилцсанаар тэдний хөгжилд идэвхтэй оролцох боломж нээгдэнэ.

Багш, сурагчийн санал болгож буй сэдвийг самбарт бичсэн байна. Жишээ нь "Сэдэвт наамал" шинэ мэдлэг олгох хичээл.

1. Хайчаар ажиллах хөдөлмөрийн аюулгүй байдлын дүрмийг дагаж мөрдөх.

2. Гүйцэтгэх ажлын дараалал болон ашиглах хэвийг бэлдсэн байх .

3. Хэвээ ашиглан бэлдэц бүрийг хайчлан бэлтгэх

4. Бэлдцүүдээ дэвсгэрт цавуудан түр тогтоох

5. Засвар хийж засан байрлуулах

Самбарт бичсэн зүйлс хүүхдүүдэд эхний ээлжинд үр дүнгээ өгөхгүй байж болох нь мэдээж хэрэг юм. Учир нь тэдний ихэнх нь уншиж чаддаггүй шүү дээ.

Тиймээс янз бүрийн дүрс ашиглан шалгуур гаргах хэрэгтэй. Ингэж ангиас ангид, хичээлээс хичээлд "Зургийн хэл"-ээр ярилцсанаар бүх насны хүүхэд мэдээлэл авах боломжтой болж байна. Хичээлийн зорилго зорилт нь шалгууруудад шингэж багтсан байхаар төлөвлөгдсөн байна.

ХОЁРДУГААР АЛХАМ

Тайлангийн хуудас бэлтгэх

Зорилго: Сурагчдын бүтээх үйл ажиллагааг хянах, үнэлэх үйл ажиллагааг хүртээмжтэй болгон хялбарчлах, багш, сурагчдын аль алиных нь хувьд тайлангийн баримт бичиг бөглөхөд шаардагдах цаг хугацааг бууруулах; энэ бүхэн ихэдвэл сурагчдын өөрийгөө үнэлэх үйл ажиллагааг хаадаг талтай. Тайландаа багш дөрвөлжин цаас

ашигладаг. 1-р ангийнхан өөрсдөө бэлтгэдэг. Хоёр босоо шулуунаар хуудсаа 3 хуваан зурсан байна. Эхний хэсэгт нь овог нэр, удаах хэсэгт нь шалгууруудын дугаар байна.

ГУРАВДУГААР АЛХАМ

Харилцан болон өөрийн үнэлгээ хийх

(Сурагч сурагчийгаа, багш өөрийгөө, багш багийг, баг багийг гэх мэт үнэлнэ.)

Зорилго: харилцан болон өөрийн үнэлгээг нягт нямбай, бодитой, харагдахуйцаар, үр дүнтэй болгох

Эхний багана нь таамаглал буюу өөрийн үнэлгээнийх юм.

Оролцогч хүүхэд бүр хичээл эхлэхээс өмнө шалгуур тус бүрийн дугаарын ард таамнал, төсөөллөөрөө (+), (-), (?) гэсэн тэмдэг тавьсан байна. Энэ нь сурагч өөрийн чадвар боломжийг үнэлж байна гэсэн үг юм. Тэр үед багш шаардлагатай сурах бичгийн мэдээлэл буюу хуудсыг зааж өгч болно.

Суралцагч ажлаа сайн гүйцэтгэсэн хэмээн үзэж байгаа бол (+) тэмдэг тавина. Зөв хийсэн эсэхдээ эргэлзэж буй бол (-) тэмдэг тавина. Ямар нэг зүйл ойлгохгүй байгаа бол (?) тэмдэг тавина. Энэ маягаар сурагчид өөрийн сурах үйл ажиллагааг өөрөө шалгаж үр дүнг үздэг.

Хоёрдугаар багана нь харилцан үнэлгээнд зориулагдсан юм. Үүнд бүх шалгуурыг хамрахгүй байж болно. Нэг сурагч, эсвэл багш бусад суралцагчийн гүйцэтгэлийн түвшнийг бодитойгоор тодорхойлох боломжийг олгодог учир их чухал хэсэг юм . Ийм маягаар ерөнхий жагсаалтаас эцсийн үр дүнгийн чанарыг тодорхойлж болно.

Сурагчид тайлангаа харилцан солилцож (зарим тохиолдолд сурагч өөрийн ажлаа бусадтай хуваалцах дургүй ч байж болно. Түүнийг багш зохицуулна) ажлын гүйцэтгэлийг тэмдгүүдээр тодорхойлно.

Түүнчлэн сурагчид аман болон өөр зурган үнэлгээгээр ч өөрсдийгөө үнэлж болно. Эхний хэсэгт үнэлгээний үг яриа эерэг тал руу явагдсан бол дараа нь асуудлын мөн чанарыг хөндсөн зөвлөмжийн тал руугаа ханддаг.

Ажлыг гүйцэтгэх явцад багш үнэлгээний үйл явцыг ажиглан хянаж, шаардлагатай үед нь туслах, зарим үед ганцаарчилсан зөвлөгөө өгнө.

Хичээлийн бататгал хэсэг буюу шалгуур бүрээр явагдах аман үнэлгээний явцад багш

сурагчдын нийтлэг бөгөөд хувийн зан чанарын талаар сурган хүмүүжүүлэх судалгаа хийж явна. Хичээлийн төгсгөлд сурагчид багшид бичил тайлангаа хураалгана.

ДӨРӨВДҮГЭЭР АЛХАМ

Багшийн ажил

Зорилго: Сурагч бүрийн сургалтын үр дүнг задлан шинжлэх; хичээлийн явцын бэрхшээл хүндрэл болон өөрийн үнэлгээний хэрэгжилтийг тодорхойлох, зөвлөгөө, практик туслалцаа хэрэгтэй байгаа сурагчдыг тодорхойлох.

Хичээлийн төгсгөлд (хичээлийн дараа ч байж болно) сурагчид 2 шулуунаар эхнийх нь дундуур нь, дараагийнх нь 3 ны 2- оор хуваасан (нугалах аргаар хувааж ч болно) А 4 цаасан дээр үйл ажиллагааныхаа үр дүнг тайлагнана.

Цуглуулсан бичил тайлангуудаа амжилттай сайн (у +) гүйцэтгэсэн; ажил орж (+ –) гүйцэтгэсэн, тусламж авч болон онцгой анхаарал татаж (у –)гүйцэтгэсэн гэсэн 3 түвшинд ангилж наана.

Шалгуур тус бүрээр тулгарах хүндрэлүүдийг ангилж ялгана. Энэ маягаар багш богино хугацаанд сурагчдад (нэг болон нэг хэсэг сурагчдад) тулгарч буй бэрхшээл саадыг тодруулж авдаг.

Бичил тайланг тараах үеэр сурагч (3-р баганаан дахь) тэмдэглэгээг хийдэг.

Бичил тайланд анализ хийх үедээ багш өөрөө өөрийн таних тэмдэглэгээг хийдэг. Жишээ нь үнэлгээ давхардвал улаанаар дугуйлах, давхардаагүй бол улаан цохоор тэмдэглэх... гэх мэт. Хэрвээ бичил тайланд нэг л (+ –) болон (–) тэмдэг байвал түүнийг хавтгайн тохирох хэсэгт харгалзуулж тавина.

Тэмдэглэгээ нь (+ –) байвал багшид сурагчийн ажилтай нэг бүрчлэн танилцаж зөвлөгөө өгч тулгарсан асуудлыг шийдэх хэрэгтэй гэсэн мэдээлэл болно. Тэмдэглэгээ нь (у –) байгаа суралцагч нь асуудалтай байдаг, тэрээр тэдгээрийг шийдвэрлэхэд хувь хүний туслалцаа хэрэгтэй юм байна гэдгийн дохио юм. (?) тэмдэгтэй бол хүүхдэд ямар нэг ойлгомжгүй зүйл байгаа ба илүү их тулж ажиллах шаардлагатай байгаагийн дохио юм.

Харилцан болон өөрийгөө үнэлэх үнэлгээ нь давхцахгүй байж болох юм. Ийм тохиолдолд үнэлгээ нь үр дүнтэй багатай байх бөгөөд багш сурагчтай нэг бүрчлэн ярилцах юмуу, хийсэн

ажилтай дахин танилцах, эсвэл сурагчдаар дахин үнэлүүлэх хэрэгтэй гэсэн үг юм.

Энэ маягаар багшийн хавтсанд өгөгдсөн сэдвээр болон хичээлийн тоогоор хүүхэдтэй ажиллах үйл ажиллагааны арга зүй хуримтлагдсаар байдаг.

Түүнчлэн багшийн хувьд сурагчдын мэдлэг, үр чадварыг дээшлүүлэх сургалтын үйл ажиллагааны мөн чанарыг харуулсан сурган хүмүүжүүлэх тэмдэглэлтэй болж буй нь багш бэрхшээлийг даван туулах арга зүйд суралцах боломж нээгдэж байна гэсэн үг юм. Цуглуулсан мэдээлэлдээ тулгуурлан сургалтын үйл ажиллагаандаа анализ хийх болон эцэг эх, сурагчидтай эргэх холбоо тогтоон ажиллах нөхцөл бүрддэг.

ТАВДУГААР АЛХАМ

Эргэх холбоо

Зорилго: Тодорхой асуудлыг шийдэхэд нь сурагчдын бие даасан хандлагыг дэмжих, цаашдаа мэдлэг, үр чадвараа дээшлүүлэх боловсроход нь туслах.

Багш нарын сургалтын үйл ажиллагааг задлан шинжлэх нь сургалт болоод хувь хүний төлөвшил, хөгжилд нь маш чухал юм. Сурагчидтай хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулж, тохиолдсон хүндрэл бэрхшээлийг даван туулах, шинэ мэдлэг олгоход тодорхой амжилт олно. Эргэх холбоо нь туслалцаа авах шаардлагатай байгаа хүүхдэд ганцаарчилсан зөвлөгөө өгөх (хэрэв энэ шаардлагатай байгаа бол), нэмэлт мэдээлэл өгөх (эрхлэгчийн заавар, зөвшөөрлийн дагуу), нэг ангийнхны туслалцаа үзүүлэх, эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх, хувь хүнийг дэмжих, анги танхим тохижилтод туслалцаа үзүүлэх үүрэгтэй. Эцэг эхийн эргэх холбоо нь "Мэдээллийн хуудас"-аар дамжуулан системтэйгээр (улиралд нэг удаа) эцэг эхийн нэрээр өдрийн тэмдэглэлдээ баяжилт хийлгэх хэрэгтэй юм.

Мэдээллийн хуудасны агуулга нь: Хүндэт эцэг эхчүүд ээ! Бид...р улиралд технологи (дүрслэх урлаг)-ийн хичээлээр 1) ... 2) ... зүйлсийг үзэж судаллаа. Бид дараах мэдлэг үр чадварыг үүгээр эзэмшсэн байх ёстой. Үүнд : 1) ... 2) ...

Ийм мэдээллийг зөвхөн асуудалтай суралцагчийн эцэг эхэд л өгнө. Мэдээллийг сурагчдын суурь материалд эцэг эхийн анхаарлыг хандуулж ажиллахаар боловсруулсан байна.

...Бидний өмнө тохиолдсон хүндрэл бэрхшээлийг даван туулахад дэмжлэг, тусламж үзүүлсэн (Эцэг эхийн нэрийг зааж) Танд маш их



баярлалаа.

Хүндэтгэсэн багшгэх мэтээр бичнэ.

ЗУРГААДУГААР АЛХАМ

Сургах үйл ажиллагаанд хийх анализ

Зорилго: Практик үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд тохиолдох хүндрэл, тэдгээрийн шалтгааныг тодорхойлох; боловсролын үйл явцыг сайжруулах, нягтлах, эргэцүүлэх, асуудлыг зөв шийдвэрлэх, улмаар хичээлийн жилийн эцэст багш сурагчдад учирч байгаа бэрхшээл, асуудлыг харгалзан (бичгээр) сургах, сурах үйл явцыг задлан шинжилж, бэрхшээлийг даван туулсан хүмүүсийг тодорхойлж, бэрхшээлийг арилгах арга, ирэх хичээлийн жилд энэ сэдвээр сурах үйл явцыг сайжруулах аргачлал боловсруулж, ажлын чиглэлийг тодорхойлсон хэтийн төлөвийг нээж, дүн шинжилгээ хийх нь ажлын амжилтын гол түлхүүр гэдгийг батлах явдал юм.

Арга зүйн захидлын агуулгад анхаарлыг хандуулахдаа "Судалгаанд суурилан сурагчдын сурлагаар хоцорсон шалтгаан, шинээр бий болж буй асуудлыг шийдвэрлэх арга замыг харуулсан байх шаардлагатай".

Гэхдээ багш нар сургалтын явц дүнд (хичээл тус бүрийн дараа) судалгаа хийх нь жилийн туршид хүүхдэд олгох хичээлийн агуулга, тэдэнтэй ажиллах арга зүйгээ өөрчлөх өргөн боломж олгодог байна гэдгийг тодруулах шаардлагатай юм. Өгөгдсөн аргыг сургууль хамт олноороо бүтээлчээр хэрэгжүүлэх нь үр ашигтай байна.

Анги бүрт хийж буй бичил тайлан нь гүйцэтгэсэн ажлын чанарыг тодорхойлох багшийн хамтын үнэлгээнд зориулагдана.

Бүлгүүдийн хооронд бичил тайлангаа солилцох нь хамтын үнэлгээ хийх боломж олгодог. Харилцан үнэлгээний явцад (+ –) болон (–) тэмдэглэгээнүүд илрэх нь асуудал байгааг илтгэнэ. Багш хичээлийн явцад болон хичээлийн дараа асуудлын уг сурвалжийг тодорхойлох шаардлагатай.

Сурагчдын бүтээлч үйл ажиллагаанд өөрийн үнэлгээг нэвтрүүлэх нь зүйтэй санаа бөгөөд бусдын ажилд арга зүйн үндэслэл болж өгнө.

Орчуулсан: МУБИС-ийн НХУС-ийн Дүрслэх урлагийн тэнхимийн багш, дэд профессор З. Ба ярмагнай

МУБИС-ийн БС-ийн СӨБСС-ийн Арга зүйн

тэнхимийн багш, магистр Б. Мягмар

МУБИС-ийн БС-ийн Ар.БС-ийн багш, магистр Б. Мөнх-Ачит